



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧИЙН ТОГТООЛ

2015 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 08

Алтай

Хуралдааны тов зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын наймдугаар хуралдааныг 2015 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Алтай хотод хуралдуулахаар товлон зарлаж дараах асуудлыг хэлэлцэхээр тогтсугай.

1. Аймгийн 2015 оны төсөв тодотгох тухай
2. Алтай хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө
3. Дэлгэр сумын хөгжлийн мастер төлөвлөгөө батлах тухай
4. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь хэмжээг шинэчлэн тогтоох
5. Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай

2. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтын ажлыг хангаж ажиллахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Л.Болормаа/, Засаг даргын Тамгын газрын дарга /П.Золжаргал/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА



А. ДЭЛГЭРЖАРГАЛ

02 000012